



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 6/102

Сайнцагаан сум

Ж.Гэрэлтуяаг ажилд томилох тухай



Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 21, 23 дугаар зүйлийн 23.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаал батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам"-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жавзангийн Гэрэлтуяаг тус газрын үйлчлэгчээр 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс томилж, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулсугай.
2. Үйлчлэгч Ж.Гэрэлтуяаг төрийн үйлчилгээний албан тушаалын ТҮ-1 дүгээр зэрэглэлийн 3 дугаар шатлалаар цалинжуулахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хувийг ажилтны хувийн хэрэгт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн, /цагдаагийн дэслэгч Л.Мөнхчимэг/, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилга өгч ажиллахыг аж ахуйн ажилтан /цагдаагийн дэслэгч Х.Доржбямба/ нарт тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ДЭД ХУРАНДАА

B. Munkhbat

Б.МӨНХБАТ





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 6/103

Сайнцагаан сум

Цагдаагийн ахлагч Э.Мөнхбаярыг албанаас
чөлөөлж, цагдаагийн цол хураах тухай


Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 72 дугаар тогтоолоор баталсан "Цагдаагийн бага, дунд, ахлах цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2.6, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан "Албанаас чөлөөлөх, халах /код-911/ журам"-ын 911 дүгээр зүйлийн 911.3.6, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам"-ын 136 дугаар зүйлийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаа жолооч, цагдаагийн ахлагч Эрдэнэтуяагийн Мөнхбаяр нь өөрийн санаачилгаар албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгон албанаас чөлөөлж, "цагдаагийн ахлагч" цолыг хураасугай.


2. Э.Мөнхбаярын ажлыг хүлээлцүүлж, холбогдох тооцоо хийхийг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ДЭД ХУРАНДАА



Б.МӨНХБАТ





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 13 өдөр

Дугаар Б/104

Сайнцагаан сум

Цагдаагийн хошууч Р.Саранболдын
цалинг шинэчлэн тогтоох тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 87 дугаар зүйлийн 87.9.1, 87.9.2, Засгийн газрын 2014 оны 99, 2019 оны 472 дугаар тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох /код 924/ журам”-ын 924.4.1, 924.4.2, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам”-ын 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн Б/860 дугаар тушаалаар тус газрын Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн даргаар томилогдсон цагдаагийн хошууч Раднаабазарын Саранболдын албан тушаалын сарын үндсэн цалинг ТТ13 дугаар зэрэглэлийн 4 дүгээр шатлалаар, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 25 /хорин тав/, цолны нэмэгдлийг 30 /гуч/, алба хаасан хугацааны нэмэгдлийг 25 /хорин тав/ хувиар тус тус тооцож олгосугай.

2. Цагдаагийн хошууч Р.Саранболдын цалин хөлсийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохих журмын дагуу тушаалд заасан хувь хэмжээгээр тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ДЭД ХУРАНДАА

Б.МӨНХБАТ





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021. оны 09 сарын 13 өдөр

Дугаар 6/105

Сайнцагаан сум

Цагдаагийн ахлах дэслэгч М.Бат-Эрдэнэд
сахилгын шийтгэл оногдуулах тухай


Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 81 дүгээр зүйлийн 81.4.1, 81.6, 97 дугаар зүйлийн 97.1 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/170 дугаар тушаалаар баталсан “Сахилгын шийтгэл оногдуулах /код 914/ журам”, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам”-ын 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:



1. Цагдаагийн газрын даргын 2021 оны 13 дугаар зөвлөлийн хуралдааны шийдвэрээр иргэнтэй зүй бус харьцсан, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 2.4.1, 2.4.13 дахь хэсгийг зөрчсөн тул Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасныг баримтлан Дэлгэрхангай сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Мөнхболдын Бат-Эрдэнэд сануулах сахилгын шийтгэл оногдуулсугай.

2. Цагдаагийн ахлах дэслэгч М.Бат-Эрдэнэд дахин зөрчил дутагдал гаргахгүй байх, хариуцсан алба хаагчдад өдөр тутамд тавих хяналтаа сайжруулж, зааварчилгаа өгч, үр дүнг тооцож ажиллахыг Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Р.Саранболд/-д, хүний нөөцийн санд баяржилт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Л.Мөнхчимэг/-д, сэтгэл зүйн чиглэлээр ярилцлага, судалгааг явуулан дүгнэлт хийн танилцуулахыг сэтгэл зүйч /цагдаагийн ахлах дэслэгч Ч.Сүрэнхорлоо/-д тус тус үүрэг болгосугай.

3. Цагдаагийн ахлах дэслэгч М.Бат-Эрдэнийг ёс зүйн сургалтад хамруулах, шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн албаны зөвлөлд 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг тайлбарлахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ДЭД ХУРАНДАА  Б.МӨНХБАТ





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар Б/106

Сайнцагаан сум

Алба хаагчдыг түр чөлөөлж, суралцуулах
тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9, 61 дүгээр зүйлийн 61.1.7, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн Б/866 дугаар тушаал, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах журам" /код-136/ 136.5.2-ийн "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч Энхбаярын Ёндонпэрэнлэй, эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлагч Батхуягийн Насанжаргал нарыг Хууль сахиулахын их сургуулийн "Цагдаагийн ажил-эрх зүй" эчнээ сургалтад 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөн оны 11 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд ажлаас чөлөөлж, суралцуулсугай.

2. Алба хаагчдыг суралцах нөхцөл бололцоогоор хангахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д, цалин хөлсийг зохих журмын дагуу тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ДЭД ХУРАНДАА

Б.МӨНХБАТ





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 6/109

Сайнцагаан сум

Нууц хамгаалах ажилтан, нууцын
бичээч нарыг томилж, цалингийн
нэмэгдэл олгох тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.1 дэх заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны Б/106 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, мөн даргын 2018 оны А/123 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон албаны нууцыг хамгаалах /код 114/ журам”-ын 114.4.4, 114.5.1, 114.5.2, 114.5.4, 114.5.6, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам”-ын 136.4.2-ын “в”, “к”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус газрын эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Бадам-Очирын Бат-Эрдэнийг нууц хамгаалах ажилтнаар, эдийн засгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Хүрэлбаатарын Амарзаяаг нууцын бичээчээр тус тус томилсугай.


2. Нууц хамгаалах ажилтны албан тушаалын сарын үндсэн цалинг 20 хувь, нууцын бичээчийн албан тушаалын сарын үндсэн цалинг 15 хувь тус тус нэмж тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох хууль, тогтоомжид заасныг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг нууц хамгаалах ажилтан, нууцын бичээч нарт үүрэг болгосугай.


4. Энэ тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн Б/63 дугаартай тушаалыг хүчингүйд тооцсугай.

5. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ДЭД ХУРАНДАА



Б.МӨНХБАТ





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 6/110

Сайнцагаан сум

Улирлын ажлын үр дүнгээр алба хаагчдад
мөнгөн урамшуулал олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйл, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам"-ын 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газрын даргын 2021 оны 14 дүгээр зөвлөлийн хуралдааны шийдвэрээр алба хаагчдын 2021 оны 3 дугаар улирлын ажлын тайлан, үр дүнг хэлэлцээд нэр бүхий алба хаагчдын албан тушаалын сарын үндсэн цалинг хавсралтад дурдсан хэмжээгээр нэмсүгэй.
2. Алба хаагчдын цалинг хавсралтад заасан хувь хэмжээгээр тооцож, бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ДЭД ХУРАНДАА

Б.Мөнхбат

Б.МӨНХБАТ

